

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

Агуулга

Аудитын код: САГ-2021/357/СТА-ТШЗ	0
1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
Аудитын зөвлөмж.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Менежментийн захидал	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

2021.02.25 № 07/526
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ...

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 24 арга хэмжээний төлөвлөгөөнд 95 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлөөс төсвийн хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан, урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн, цалин, урамшууллыг илүү тооцож олгосон, анхан шатны бүртгэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан зэрэг нийт 480,842.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 104,304.3 мянган төгрөгөөс давсан, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 42

дугаар зүйлийн 42.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Үнэн зөв байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>595,088,324.75</u>	<u>495,855,481.55</u>
33	АВЛАГА	13,881,441.21	1,539,695.60
335	Бусад авлага	13,881,441.21	1,539,695.60
3351	Байгууллагаас авах авлага	13,881,441.21	1,539,695.60
34	УРЬДЧИЛГАА	438,181,339.59	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	384,999,067.00	00.00
3471	Урьдчилгаа тооцоо	53,182,272.59	00.00
34714	Томилолтын урьдчилгаа	53,182,272.59	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>143,025,543.95</u>	<u>494,315,785.95</u>
354	Хангамжийн материал	143,025,543.95	494,315,785.95
35410	Бичиг хэргийн материал	4,246,100.00	5,446,820.00
35420	Аж ахуйн материал	124,377,882.95	475,573,372.95
35430	Сэлбэг хэрэгсэл	9,287,500.00	6,381,400.00
35440	Түлш, шатах тослох материал	5,114,061.00	6,914,193.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,760,223,757.12</u>	<u>1,767,944,129.86</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,760,223,757.12	1,767,944,129.86
392	Биет хөрөнгө	489,634,763.32	583,850,700.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	579,304,720.00	579,304,720.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-579,304,720.00	-579,304,720.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	575,186,780.06	490,241,847.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-315,445,742.99	-107,402,331.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	488,441,354.11	398,754,195.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-260,282,127.86	-199,477,510.64
39217	Ном	1,734,500.00	1,734,500.00
393	Биет бус хөрөнгө	1,270,588,993.80	1,184,093,429.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,356,657,868.57	1,488,065,523.57
39304	Хуримтлагдсан элэгдэл	-86,068,874.77	-303,972,094.57
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,355,312,081.87</u>	<u>2,263,799,611.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,015,036.06</u>	<u>37,713,165.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,015,036.06	37,713,165.00
413	Өглөг	5,015,036.06	37,713,165.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,465,026.06	00.00
4136	Бусад өглөг	2,550,010.00	37,713,165.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,550,010.00	37,713,165.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,350,297,045.81</u>	<u>2,226,086,446.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,350,297,045.81	2,226,086,446.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	304,117,253.38	304,117,253.38
51101	Өмч: - төрийн	304,117,253.38	304,117,253.38
512	Хуримтлагдсан үр дүн	2,046,179,792.43	1,921,969,193.03
51210	Өмнөх үеийн үр дүн	2,046,179,792.43	2,046,179,792.43
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-124,210,599.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,355,312,081.87</u>	<u>2,263,799,611.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,809,166,247.00	5,103,538,854.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	688,127.00	147,000,054.00
120	Нийтлэг татварын бус орлого	688,127.00	147,000,054.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	688,127.00	147,000,054.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	688,127.00	147,000,054.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,808,478,120.00	4,956,538,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,808,478,120.00	4,956,538,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,808,478,120.00	4,956,538,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,424,071,125.41	5,215,071,220.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,424,071,125.41	5,215,071,220.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,079,605,746.63	4,898,084,646.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,412,129,318.29	2,355,744,703.31
210101	Үндсэн цалин	869,311,941.36	1,316,291,483.31
210102	Нэмэгдэл	232,533,600.00	575,143,320.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	153,307,372.74	170,090,000.00
210104	Урамшуулал	156,976,404.19	294,219,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,274,400.00	326,356,300.00
210201	Тэтгэврийн даатгал	95,386,600.00	229,658,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,221,900.00	24,174,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,977,500.00	19,339,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,244,400.00	4,834,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,444,000.00	48,349,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	143,863,878.41	225,507,390.52
210401	Бичиг хэрэг	40,261,949.60	39,708,520.00
210402	Тээвэр, шатахуун	30,007,466.00	24,216,868.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,411,947.36	27,580,193.52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,182,515.45	134,001,809.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,370,928.00	71,112,910.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	579,800.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	30,133,790.00
210604	Урсгал засвар	92,791,128.00	40,979,120.00
2107	Томилолт, зочны зардал	550,127,389.00	88,313,619.00
210702	Дотоод албан томилолт	550,127,389.00	88,313,619.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,424,187,511.39	1,383,441,365.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,414,544,457.39	1,365,005,551.67
210803	Даатгалын үйлчилгээ	7,610,220.00	7,375,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	932,334.00	692,234.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	299,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,500.00	10,068,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	315,652,321.54	447,608,357.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,566,110.00	139,806,127.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	214,086,211.54	307,802,230.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	344,465,378.78	316,986,574.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	142,181,330.00	94,934,841.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	91,154,189.00	21,420,823.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,617,164.00	65,614,018.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,409,977.00	7,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	202,284,048.78	222,051,733.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	202,284,048.78	222,051,733.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,385,095,121.59	-111,532,366.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	12,678,232.88
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	00.00	11,903,818.88

225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	774,414.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-12,678,232.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,385,095,121.59	-124,210,599.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,847,586,120.00	4,956,538,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,847,586,120.00	4,956,538,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,808,478,120.00	4,956,538,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,808,478,120.00	4,956,538,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,108,000.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	39,108,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,847,586,120.00	4,956,538,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,847,586,120.00	4,956,538,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,502,620,741.22	4,639,552,225.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,445,809,996.67	2,356,496,178.97
210101	Үндсэн цалин	903,838,178.53	1,317,061,078.97
210102	Нэмэгдэл	232,533,600.00	575,125,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	153,307,372.74	170,090,000.00
210104	Урамшуулал	156,130,845.40	294,219,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,461,900.00	326,356,300.00
210201	Тэтгэврийн даатгал	95,574,100.00	229,658,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,221,900.00	24,174,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,977,500.00	19,339,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,244,400.00	4,834,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,444,000.00	48,349,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	129,353,043.36	122,073,432.52
210401	Бичиг хэрэг	36,412,540.00	33,044,300.00
210402	Тээвэр, шатахуун	28,433,400.00	28,080,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,415,807.36	29,691,063.52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,091,296.00	31,258,069.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	174,809,326.00	271,708,838.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,743,770.00	32,301,308.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	195,736,410.00
210604	Урсгал засвар	119,065,556.00	43,671,120.00
2107	Томилолт, зочны зардал	534,286,833.00	87,877,713.00
210702	Дотоод албан томилолт	534,286,833.00	87,877,713.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,588,374,353.10	1,294,817,584.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,536,257,299.10	1,156,266,270.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,610,220.00	7,375,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	932,334.00	692,234.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	349,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,574,500.00	130,134,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	489,525,289.09	180,222,179.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	475,989,289.09	180,222,179.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,536,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	344,965,378.78	316,986,574.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	142,181,330.00	94,934,841.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	91,154,189.00	21,420,823.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,617,164.00	65,614,018.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,409,977.00	7,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	202,284,048.78	222,051,733.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	202,284,048.78	222,051,733.51
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	500,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	500,000.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	0.00	661,084,670.84	965,201,924.22
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,385,095,121.59	1,385,095,121.59
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	0.00	2,046,179,792.43	2,350,297,045.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,117,253.38	0.00	2,046,179,792.43	2,350,297,045.81
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(124,210,599.40)	(124,210,599.40)
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	304,117,253.38	0.00	1,921,969,193.03	2,226,086,446.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,002,193,800.00	4,734,487,066.49	267,706,733.51	94.6
УРСГАЛ ЗАРДАЛ	5,002,193,800.00	4,734,487,066.49	267,706,733.51	94.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,871,110,200.00	4,639,552,225.49	231,557,974.51	95.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,417,454,600.00	2,356,496,178.97	60,958,421.03	97.5
Үндсэн цалин	1,378,019,500.00	1,317,061,078.97	60,958,421.03	95.6
Нэмэгдэл	575,125,200.00	575,125,200.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	170,090,000.00	170,090,000.00	-	100.0
Урамшуулал	294,219,900.00	294,219,900.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,356,300.00	326,356,300.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	229,658,100.00	229,658,100.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	24,174,500.00	24,174,500.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	19,339,700.00	19,339,700.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	4,834,900.00	4,834,900.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	48,349,100.00	48,349,100.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	109,548,200.00	122,073,432.52	-12,525,232.52	111.4
Бичиг хэрэг	28,396,600.00	33,044,300.00	-4,647,700.00	116.4
Тээвэр, шатахуун	21,076,500.00	28,080,000.00	-7,003,500.00	133.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,803,700.00	29,691,063.52	-887,363.52	103.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,271,400.00	31,258,069.00	13,331.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	63,165,000.00	271,708,838.00	-208,543,838.00	430.2
Багаж, техник, хэрэгсэл	33,165,000.00	32,301,308.00	863,692.00	97.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	195,736,410.00	-195,736,410.00	0.0
Урсгал засвар	30,000,000.00	43,671,120.00	-13,671,120.00	145.6
Томилолт, зочны зардал	98,619,300.00	87,877,713.00	10,741,587.00	89.1
Дотоод албан томилолт	98,619,300.00	87,877,713.00	10,741,587.00	89.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,656,993,800.00	1,294,817,584.00	362,176,216.00	78.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,344,322,400.00	1,156,266,270.00	188,056,130.00	86.0
Даатгалын үйлчилгээ	7,980,000.00	7,375,680.00	604,320.00	92.4
Тээврийн хэрэгслийн татвар	966,000.00	692,234.00	273,766.00	71.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо	350,000.00	349,000.00	1,000.00	99.7
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	303,375,400.00	130,134,400.00	173,241,000.00	42.9
Бараа үйлчилгээний бусад зардал	198,973,000.00	180,222,179.00	18,750,821.00	90.6
Бараа үйлчилгээний бусад зардал	198,973,000.00	180,222,179.00	18,750,821.00	90.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,083,600.00	94,934,841.00	36,148,759.00	72.4
Бусад урсгал шилжүүлэг	131,083,600.00	94,934,841.00	36,148,759.00	72.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,000,000.00	21,420,823.00	1,579,177.00	93.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	100,083,600.00	65,614,018.00	34,469,582.00	65.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,000,000.00	7,900,000.00	100,000.00	98.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,002,193,800.00	4,734,487,066.49	267,706,733.51	94.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,002,193,800.00	4,734,487,066.49	267,706,733.51	94.7
Улсын төсвөөс санхүүжих	5,002,193,800.00	4,734,487,066.49	267,706,733.51	94.7
АЖИЛЛАГСДЫН ТОО	78	78	-	100.0
Удирдах ажилтан	3	3	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	72	72	-	100.0
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны төсвийн шууд захирагч, Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, санхүүгийн тайланг стандарт, хууль, журам, зааврын дагуу бэлтгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Л.Нямтөмөр хариуцаж хэрэгжүүлэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 22-ны өдрийн 03/197 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын хувьд ил тод, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хуулиа дээдэлсэн зарчмыг баримтлан уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

- Геологийн салбарыг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх;
- Уул уурхайн олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэрийг байгуулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Түлш (эрчим хүчний нүүрснээс бусад)-ний хангамж, нөөцийн талаарх бодлого боловсруулах, газрын тосны хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах, нүүрснээс шингэн түлш гарган авах үйлдвэрийн суурийг тавьж хөгжүүлэх, улмаар дотоодын боловсруулах үйлдвэрийг байгуулах;
- Байгалийн хий болон уламжлалт бус газрын тосны эх үүсвэрийн (нүүрсний давхаргын мятан хий, шатдаг занар, тослог элс гэх мэт) талаарх судалгаа, хайгуул, олборлолтыг дэмжин хөгжүүлж, хийжүүлэх, шингэрүүлэх замаар гүн боловсруулалт хийх, ТЭЗҮ боловсруулах, боловсруулах үйлдвэр байгуулах;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхыг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх;
- Уул уурхайн салбарт техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, байгаль орчинд халгүй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг болно.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын санхүүгийн тайлан бэлтгэх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/330 дугаар тушаалаар батлуулсан байна.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,424,070.0 мянган төгрөгийн 2 хувиар буюу 88,481.4 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээнд өөрчлөлт оруулаагүй боловч 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 104,304.4 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 91,512.5 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	13,881.4	1,539.7	(12,341.7)
Урьдчилгаа	438,181.3	0.0	(438,181.3)
Бараа материал	143,025.5	494,315.8	351,290.3
Үндсэн хөрөнгө	1,760,223.8	1,767,944.1	7,720.3
Нийт хөрөнгө	2,355,312.1	2,263,799.6	(91,512.5)
Өр төлбөр	5,015.0	37,713.2	(32,698.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,350,297.0	2,226,086.4	(124,210.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,355,312.1	2,263,799.6	(91,512.5)

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 1,539.7 мянган төгрөг болж 12,341.7 мянган төгрөгөөр буурсан нь 2017 онд ахмадын сангаас авахаар үүсгэсэн авлагыг тооцоо нийлж, залруулсантай холбоотой.

Тайлант онд нийт 438,181.3 мянган төгрөгийн урьдчилгаа дансны үлдэгдлийг хааж, зардлаар хүлээн зөвшөөрсөн бөгөөд 384,999.1 мянган төгрөгийн ашигт малтмалын төрөлжсөн судалгаанд сансрын зураг ашиглан тайлал хийх сэдэвчилсэн судалгааны ажлыг

гүйцэтгэсэн, Канад улсад зохион байгуулагдах Чуулга уулзалтын арга хэмжээ цуцлагдсантай холбоотойгоор өмнөх онд урьдчилан шилжүүлсэн 53,182.27 мянган төгрөгийг буцаан авсан байна.

Тайлант оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн 1,539.7 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 494,315.8 мянган төгрөг болж 351,290.2 мянган төгрөгөөр өссөн нь МУ-ын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 14 дэх удаагийн буюу 2019 оны нэгтгэлийн тайлан, газрын тосны баялгийн, гамшгийн, хэрэглэгчийн үнэлгээ, судалгааны үнэлгээний тайлангууд, салбарын хэрэгцээний хууль эрх зүйн эмхэтгэл, ном товхимол, Короновируст цар тахлын үед ажилтан, албан хаагчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хөдөлмөр хамгааллын хэрэгсэл зэргийг бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгөнд урсгал төсвөөс 169,759.0 мянган төгрөгийн, сайдын багцын хөрөнгө оруулалтын зардлаас бэлтгэж үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 145,763.6 мянган төгрөгийн нийт 315,522.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрлийн дагуу 358,747.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 37,713.2 мянган төгрөг болж өссөн нь зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын үлдэгдлийг Төрийн сангийн дансны эрх нээгдээгүйгээс шалтгаалан шилжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,226,08.5 мянган төгрөг болж 124,210.6 мянган төгрөгөөр буурчээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 705,627.3 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 791,000.0 мянган төгрөгөөр буюу 17.9 хувиар өссөн нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс авах зардал нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 6,843,621.5 мянган төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулалгүй баталсан ч төсөвт тодотгол хийн 1,841,427.7 мянган төгрөгөөр бууруулж 5,002,193.8 мянган төгрөгөөр баталсан нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 1,049,564.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардлаас 220,872.0 мянга, томилолт зочны зардлаас 366,621.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлаас 121,955.4 мянган төгрөгийн зэрэг зардлыг бууруулсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,956,538.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 4,734,487.1 мянган төгрөгийг зарцуулж 222,051.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 4,734,487.07 мянган буюу 94.6 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 87,858.19 мянган төгрөгөөр, мэдээлэл сурталчилгааны зардлыг 21,750.0 мянган төгрөгөөр, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг 43,405.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг

36,148.76 мянган төгрөгөөр, олборлох үйлдвэрлэл, ил тод байдлын санаачилгын зардлыг 32,889.78 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 107 мэдээллээс 99 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 318,158.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 24,837.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгснөөс албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, 4 зөвлөмжийн хэрэгжүүлэн ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 675,588.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 194,746.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,984.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 468,348.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 10,509.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дансанд 194,746.0 мянган төгрөгийн МУ-ын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 14 дэх удаагийн буюу 2019 оны нэгтгэлийн тайлан, газрын тосны баялгийн, гамшгийн, хэрэглэгчийн үнэлгээ, судалгааны үнэлгээний тайлангууд, салбарын хэрэгцээний хууль эрх зүйн эмхэтгэл, ном товхимол зэргийг хүлээн авч бүртгэснийг Бараа материалын дансанд бүртгэхээр залруулга хийлгэлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн 480,842.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчлөөс 1,984.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 468,348.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ажилтнуудад төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо нийт 312,410.5 мянган төгрөгийг илүү олгосон, "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай худалдан авалт хийх санхүүжилт олгосныг 4,925.0 мянган төгрөгийг үрэлгэн, 77,170.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, цалин хөлстэй холбоотой тушаал шийдвэр гаргахдаа холбогдох хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн урсгал зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх, зөрчлийг давтан гаргаж, тайлант онд 73,834.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, мөн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч баримт материалыг эцэслэж дуусаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3. Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудад унааны мөнгө 1,984.5 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон унааны нөхөн олговрыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 10,509.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Бүх нийтийн хөл хорионы дэглэм тогтоосонтой холбоотой аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгөд биет тест хэрэгжүүлэх, е-баримтын гүйлгээ тулгах горим сорил хэрэгжүүлээгүй тул тухайн асуудлыг завсрын аудитаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө ашиглалттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 5 автомашины 4 нь ашиглалтын хугацаа дуусаж үлдэх өртөггүй болсон ба автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын

хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох стандарт, хууль, журам, зааврыг мөрдөөгүй байх, хөрөнгийн үнэлгээ тодорхой бус байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Автомашиньг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх ,

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч асуудлын бүртгэлээр баталгаажуулсан.

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад нийт цэвэр мөнгөн гүйлгээ, мөнгөн хөрөнгийн эхний эцсийн үлдэгдлийг 1,469,865.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн байдлын тайлан, тодруулгад авлагын эхний үлдэгдлийг 2,029.0 мянга, эцсийн үлдэгдлийг 1,539.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- ХХОАТ-ын 2,029.0 мянган авлагыг нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаар бүртгэсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөө, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг дутуу илэрхийлсэн,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2. "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын 3 дугаар хавсралтын 6.7 "Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдлийг хасаж тодорхойлсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайланд тодорхойлогдсон "нийт цэвэр мөнгөн гүйлгээ" гэсэн дүнтэй тэнцүү байна", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 2.1.4 "Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнээс зөрүүтэй илэрхийлэгдэх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг холбогдох стандарт, заавар журмын дагуу хөтөлж, үнэн зөв тайлагнаж байх;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3. Анхан шатны бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бараа материалын орлогын баримтыг тулган шалгахад 7,912.4 мянган төгрөг, зарлагын баримтыг тулган шалгахад 567.8 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл: Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байх, анхан шатны баримтгүй гүйлгээг данс бүртгэлд тусгасан байх;

3.3. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, холбогдох стандарт, хууль, журмыг мөрдөж ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			САГ-2020/357/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Албан ажлын суудлын машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудад унааны мөнгө 1,984.5 мянган төгрөгийг илүү олгосон.	1,984.5	Төлбөрийн акт тогтоох	ТНБД, Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
2	Тайлант онд төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгоходоо холбогдох журамд заасан хувиас хэтрүүлэн нийт 312,410.5 мянган төгрөгийг илүү олгосон, "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай худалдан авалт хийх санхүүжилт олгосныг 4,925.0 мянган төгрөгийг үрэлгэн, 77,178.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.	394,513.5	Албан шаардлага өгсөн	ТНБД, Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
3	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх зөрчлийг давтан гаргаж, тайлант онд 73,834.9 мянган төгрөгийн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн, мөн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч баримт материалыг эцэслэж дуусаагүй байна.	73,834.9	Албан шаардлага өгсөн	ТНБД, Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
4	Тус яамны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 5 автомашины 4ш нь ашиглалтын хугацаа дуусаж үлдэх өртөггүй болсон ба автомашиныг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй.	-	Зөвлөмж өгөх	ТНБД, Ахлах нягтлан бодогч	Г.Нандинжаргал Б.Ганчимэг
5	Мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад нийт цэвэр мөнгөн гүйлгээ, мөнгөн хөрөнгийн эхний эцсийн үлдэгдлийг 1,469,865.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, Санхүүгийн байдлын тайлан, тодруулгад авлагын эхний үлдэгдлийг 2,029.0 мянга, эцсийн үлдэгдлийг 1,539.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, ХХОАТ-ын 2,029.0 мянган авлагыг нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаар бүртгэсэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланд Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөө, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг дутуу илэрхийлсэн,	2,029.0	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Б.Ганчимэг
6	Бараа материалын орлогын баримтыг тулган шалгахад 7,912.4 мянган төгрөг, зарлагын баримтыг тулган шалгахад 567.8 мянган төгрөгийн бараа материалыг баримтын бүрдэлгүй гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан.	8,480.2	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Б.Ганчимэг
ДҮН		480,842.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 27/А0160057
САГ-2021/357/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны аппаратын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнуудад унааны мөнгө 1,984.5 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж тус тус заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Унааны илүү олгосон 1,984.5 /нэг сая есөн зуун наян дөрвөн мянга таван зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь Аудитын хяналт шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, ахлах нягтлан бодогч Б.Ганчимэг нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Л.НЯМТӨМӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 97/А0160057

Улаанбаатар хот

САГ-2021/357/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх зөрчлийг давтан гаргаж, тайлант онд 73,834.9 мянган төгрөгийн урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн, мөн эд хөрөнгийн тооллого хийсэн боловч баримт материалыг эцэслэж дуусаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ахлах нягтлан бодогч Б.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Л.НЯМТӨМӨР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 98/A0160057
САГ-2021/357/СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо холбогдох журамд заасан хувиас хэтрүүлэн ажилтнуудад нийт 312,410.5 мянган төгрөгийг илүү олгосон, "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай худалдан авалт хийх санхүүжилт олгосныг 4,925.0 мянган төгрөгийг үрэлгэн, 77,178.0 мянган төгрөг, нийт 82,103.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсөв захирагч нь цаашид цалин хөлстэй холбоотой тушаал шийдвэр гаргахдаа холбогдох хууль журамд нийцүүлж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид холбогдох хууль журам, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллаж алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ахлах нягтлан бодогч Б.Ганчимэг нарт даалгав.
- 3.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Л.НЯМТӨМӨР

